

ОВОГ НЭР

Таны гэрийн байдлын талаар судалгаа хийж байгаа Лицензийн Нөөцийн Салбарын (DLR) ажилчин нь танд хариу мэдэгдэл хийх нь их чухал арга хэмжээ юм. Тус асуудлууд бол таны гэр бүлийн орчин, боловсрол, ашиг сонирхолууд, аж амьдралын байдал, хамаатан садан, хүүхдүүдээ өсгөх талаар гарах санаа ба таны итгэдэг шашин шүтлэг зэрэг бол энэ үйлдлийг үйлдэж эхлэх анхны алхамд тооцогдоно. Үүнд зөв эсвэл буруу хариулт өгнө гэж байхгүй. Хэрэв танд хувьчлан асуух ямар нэгэн нэмэлт асуух зүйл гарч ирвэл заасан газар, байрыг тэмдэглэнэ үү.

Таны DLR лицензийн ажилтан/гэр бүл судлаач ажилтан гэрийн чинь тухай судалгаагаа эхлэхийн өмнө энэ бүх мэдээллүүдтэй танилцах ба ярилцлагын үед суурь болгон ашиглана. Хариулт өгөхдөө дэлгэрэнгүй байна уу.

Хэрэв та энэхүү маягтуудад цахим маягаар хариу өгмөөр байвал та маягтыг доорх холбоосоос ачаалж болно:

https://www.dshs.wa.gov/fsa/forms?field_number_value=&title=&=Apply Энэхүү маягтыг ачаалах бол маягтын дугаар болох 15-276 дугаарыг оруулна уу. Та гарын үсэг зурсан баримтын хуулбарыг өөрийнхөө лицензийн ажилтан/гэр бүл судлаач ажилтанд мэйлээр явуулж болох ба/эсвэл тэдэнд хатуу хуулбарыг өгж болно.

Өргөдөл гаргагч/хүүхэд асрагч бүр энэхүү маягтыг бөглөх шаардлагатай. Хэрэв та асуултуудын зарим хэсэгт хариу өгөхөөс түдгэлзэж байгаа эсвэл нэмэлт туслалцаа авах хэрэгцээ гарвал, үүний тухай өөрийн лицензийн ажилтан/гэр бүл судлаач ажилтантай сайтар ярилцана уу.

Өргөдөл гаргах шалтгаан

1. Та ямар учраас гэрээс гадуур хүүхэд асрах ажиллагааны зөвшөөрөлгүй асрагч хийх эсвэл дэмжигч эцэг эхийн үүргийг гүйцэтгэх ажлыг хийх сонирхолтой байна вэ?

А. Өргөдөл Гаргагчийн Тухай Суурь Мэдээлэл

Гэр бүлийн тухай мэдээлэл:

1. Та хаана төрсөн ба өсөж бойжсон бэ?
2. Таныг өсгөсөн хүн (хүмүүсийн) нэр ба ямар төрлийн хамаатан болохыг тодруулна уу:
3. Та өсөж бойжиж байхдаа өөрийн эцэг эх/асрагч нартай харьцаж байсан харьцаа холбоо ба одоогийн харилцааны талаар ярина уу.
4. Та өөрийнхөө бүх ах дүү нарын нэрс, тэдний нас ба байрлалын жагсаалтыг гаргана уу. Та өсөж бойжиж байхдаа ах дүү нартайгаа харьцаа ямар байдалтай байсан ба мөн одоо тэдэнтэй харилцаа холбоо ямар байдалд байгаа вэ?
5. Таны гэрт байх хүүхдүүд төрөл садан нартай чинь ямар харилцаатай байх вэ? Үүнд ямар нэгэн асуудал гарах уу?

6. Та өөрийнхөө хүүхэд насны тухай ба та гэртээ амьдарч байхад ямар байдалтай амьдардаг байсан талаар бичнэ үү.

7. Та өөрийгөө ямар өнцөг байдлаар харж байдаг, өөрийн хувийн шинж чанараа тайлбарлан бичнэ үү.

8. Таны гэр бүл ба найзууд таныг ямар байдал өнцөгөөс хардагийг тайлбарлана уу.

Боловсрол:

1. Таны эзэмшсэн, дүүргэсэн боловсролын хамгийн дээд зэрэг ямар вэ?
2. Өөрийнхөө авсан зэрэг/сертификатуудыг олгосон огноотой нь ба аль байгууллага/дээд сургуулиас авсан зэргийн жагсаалтыг гаргана уу (GED эсвэл дээд сургуулийн дипломыг оруулна уу).

3. Таны гэрт байгаа хүүхдүүдэд та ямар боловсролын түвшинг олгуулахыг хүсдэг вэ, ямар боловсролтой болгох хүсэлтэй?

Ажлын Түүх / Цэргийн Алба:

1. Та цэргийн алба хааж байсан уу? Тийм Үгүй
_____ -ээс _____ -хүртэл
Зэвсэгт Хүчний Салбар _____ Цол _____
Хүлээсэн үүргийн төрөл _____
2. Та одоогийнхоо ажлаас эхлээд өөрийн хийж байсан ажлуудыг нэрлэнэ үү.

3. Та өөрийнхөө ажлын жирийн долоо хоногийн өдрүүд ба цагуудын жагсаалтыг гаргаж бичнэ үү.
4. Гэрт чинь байх хүүхэд таны ажлын хуваарьт ямар өөрчлөлт өгж болох талаар бичнэ үү.
5. Хүүхэд асрамжийн талаар та ямар төлөвлөгөөтэй байна вэ?
6. Гэрээс гадуур асрагдах хүүхэд эмчийн үзлэгт орох, аль нэг газарт очих, ямар нэгэн уулзалт гэх мэтийн ажилтай байж болно. Та энэхүү ажиллагаануудыг цагт нь яаж гүйцэтгэж байх талаар бичнэ үү.

Ач холбогдол, Зорилгууд, Сонирхолууд ба Үйл Ажиллагаанууд:

1. Өөрийнхөө ач холбодлыг тайлбарлана уу.
2. Өөрийнхөө хувийн ба гэр бүлийн зорилгыг тайлбарлана уу.
3. Таны сонирхолууд ба/эсвэл хобби юу вэ?

Соёлын Өв Уламжлал

1. Та гэр бүлийнхээ соёлд яг ямар ач холбогдол өгдөг вэ? Хувь хүний соёлын суурь гэдэг нь гэр бүлийн уламжлалууд, заншил, шашин, яс үндэс ба амьдралын байдал зэргийг хэлнэ.

2. Та хүүхдэд өөрийнх нь өв залгамжлал, соёлыг нь хадгалуулж үнэлүүлэх талаар яаж тусалж байх талаар тайлбарлана уу.

3. Таны эх хэл ямар вэ?

Та бусад хэлээр түгдрэхгүй ярьдаг уу, сайн эзэмшсэн үү? Тийм Үгүй

Хэрэв тийм бол, ямар хэл (-үүд) вэ?

В. Төрөл садан

Гэр бүлийн хүн / Хамтран амьдрагч:

1. Та өөртөө хамгийн чухал ач холбогдолтой хамаатан ба өөрийнхөө гэр бүлийн/иргэний/гэрийнхээ хамтран амьдрагчийн түүхийг бичнэ үү. Хуримласан огноо, салсан огноо/үгүйсгэл/татан буулгалт ба яагаад эцэс болсон, салсан тухай боломжоороо тайлбар хийнэ үү.
2. Хэрэв гэрлээгүй бол хүүхэд харахад чинь нөлөө үзүүлж болох төрөл садангуудаа нэрлэнэ үү.
3. Хамтран амьдрагч, түншийнхээ талаар бичнэ үү.
4. Түнштэйгээ хамт та шийдвэр яаж гаргадаг ба ялгаа зөрчил гарвал яаж шийдвэрлэдэг талаар бичнэ үү?
5. Хэрэв таны асрах хүүхэд таны харьцааны саад бэрхшээл, ямар нэгэн нөлөө үзүүлбэл танд ямаршуу санагдах ба та юу хийх вэ?

Хүүхдүүд: (Хэрэв танд хүүхэд байдаггүй бол дараачийн хэсэг рүү шилжинэ үү)

1. Өөрийн бүх хүүхдүүдийн талаар бичнэ үү (бага насны буюу насанд хүрсэн), тэдний нас ба газар зүйн байрлалыг оруулна уу.
2. Хэрэв таны хүүхдэд ямар нэгэн онцгойлох хэрэгцээ тодорхойлогдсон эсвэл онцгой эмнэлгийн онош тогтоогдсон бол тэдний хэрэгцээг юунд хандуулах вэ, хэрэгцээ нь яг юунд байна вэ?
3. Таны гэрт байх хүүхэд (-үүдийн) байрлал, хөдөлгөөн нь таны өөрийн төрсөн хүүхэд (-үүд)-эд яаж нөлөөлж байна вэ?
4. Хэрэв та 18-аас доош таньтай хамт амьдардаггүй хүүхдүүдтэй бол тэдний амьдралын нөхцөл байдал, тэднийг та хир зэрэг ойрхон хардаг ба тэр хүүхдүүдэд үзүүлэх санхүүгийн хариуцлагын талаар тайлбарлана уу.
5. Таны хүүхдүүд хэзээ нэгэн цагт шүүх хэрэгт татагдаж байсан эсэх? Хэрэв тийм бол тайлбарлана уу.

Таны Гэрт эсвэл Таны Эзэмшилд байрладаг бусад хүмүүс:

1. Таны гэрт эсвэл таны эзэмшилд амьдардаг хүмүүсийн талаар богино тайлбар бичнэ үү. Тэднийг таньтай хамт амьдрах хүүхдүүдтэй яаж харьцах ёстой талаар тайлбарлана уу.

- Тэд доорхийг үйлдэхэд бэлэн эсэх: Хүүхэд /-үүд/-ийн талаар санаа тавих, халамжлах? Тийм Үгүй
Хүүхэд /-үүд/-ийг зөөвөрлөх? Тийм Үгүй
Хүүхэд /-үүд/-эд хяналт тавих? Тийм Үгүй
Хүүхэд /-үүд/-тэй хяналтгүй харьцах? Тийм Үгүй

С. Хүүхдүүдтэй Эцэг Эх шиг Харьцах Харьцаа ба Туршлага

Хүмүүжил:

1. Та хүүхэд байхдаа ямар хүмүүжил олсон бэ?
2. Та өөрийнхөө одоогийн хүмүүжлийн арга барил ба итгэлийг тайлбарлана уу (гадуур, гэрээр бус харах хүүхдүүд бие махбодийн хүмүүжилд өртөхгүй байх).

Туршлага ба Сургалт:

1. Та өөрийнхөөсөө гадна бусад хүүхдүүдтэй харьцаж байсан туршлагаа хуваалцана уу. Танд ямар нэгэн хүндрэлтэй, онцгой хэрэгцээтэй хүүхдүүдтэй ажиллаж байсан туршлага бий юу?
2. Та сургалтанд оролцох уу? Тийм Үгүй. Хэрэв тийм бол, та ямар сэдвээр оролцох сонирхолтой байна вэ?

Эцэг эхчлэлийн Хандлагууд:

1. Та хүүхдүүдийн биеэ авч явах ямар хандлагууд ба шинж чанаруудыг илүү ихээр үнэлдэг вэ?
2. Та хүүхдийн хамгийн хэцүү ааш зан эсвэл биеэ авч явах чадвараас хамгийн хэцүү хүндэд алийг тооцдог вэ? Эцэг эхийн хувьд хүнд байдалд орж байсан байдлаасаа хуваалцана уу. Иймэрхүү хэцүү үед та яг юу хийснээ бичнэ үү.

3. Таны халамжинд орсон хүүхдийг асрахад ямар ямар хүнд хэцүү байдлууд үүсэхийг та гадарлаж байна вэ?

4. Та өөрийн асрах сонирхолтой байгаа хүүхдийн талаар тайлбар бичнэ үү, үүнд нас, хүйс, хэл, эрүүл мэнд, хөгжил гэх мэтийн зүйлс орно.

5. Та танаас өөр арьсны өнгөтэй, өөр соёлтой эсвэл хүйсний хандлагатай хүүхдийг яаж асрах талаар тайлбар бичнэ үү?

6. Та эцэг эхийн халамжлал хариуцлагаа өөрийн гэр бүлтэй яаж хуваалцахаа тайлбарлана уу.

7. Та өөрийнхөө амьдралд байсан хамгийн үнэтэй хүнээ алдсан тухай буюу та дараа нь өөрийгөө яаж энэхүү хэцүү хүнд байдлаас авч гарсан талаар бичнэ үү. Энэ гарз зовлонг гэрээс гадуур байгаа хүүхэд яаж мэдэрч, юу мэдэрч байгаатай ямар холбоо байх вэ?

8. Хүүхдийг гэрээс нь гадуур асрамжийн газар байрлуулсанаас болж түүнд үүсэх сэтгэлийн шарх эсвэл гарз шаналгааны талаар та өөрийн ямар ойлголттой байдгийг тайлбарлана уу.

9. Та гэртээ байлгасан хүүхэдтэйгээ хамт зөвлөгөө авах мэтийн арга хэмжээнд оролцох уу? Тийм Үгүй

Гэр бүлийн Үйл Ажиллагаа/Дүрмүүд:

1. Хөгжөөх тоглох талаар таны гэр бүл яг юу хийдэг вэ? Та өөрийн гэр бүлийн гадуурх байнгын үйл ажиллагаанд хүүхдийг яаж оролцуулах вэ?
2. Таны гэр бүлийн дүрмүүд ямар вэ (тэтгэмжүүд, хувийн амьдрал, унтаж амрах цаг, гэрэл унтраах цаг г.м.)?

Д. Шашин / Шашин Шүтлэг ба Үйлдлүүд

1. Та хэрэв итгэдэг бол, өөрийн шашин/шашин шүтлэг ба үйлддэг үйлдлүүдийн талаар бичнэ үү.
2. Таны гэрт байрлуулсан хүүхдийн шашин/шашин шүтлэгийн үйлдлүүд хийж болох эсэхийн талаар та яг юуг хүлээж байна вэ, юу гэж бодож байна вэ?

Е. Эрүүл мэнд / Нийгэм Сэтгэцийн тухай

1. Та эсвэл таны гэр бүлийн гишүүн хууль бусаар мансууруулах бодис эсвэл буруугаар эм бодис хэрэглэдэг байсан уу?
 Тийм Үгүй
Хэрэв тийм бол аль гишүүн бэ:

<input type="checkbox"/> Өөрөө	<input type="checkbox"/> Эцэг	<input type="checkbox"/> Эмээ	<input type="checkbox"/> Ач хүү(нар)
<input type="checkbox"/> Хань эсвэл хамтран амьдрагч	<input type="checkbox"/> Хойд Эх	<input type="checkbox"/> Өвөө	<input type="checkbox"/> Үеэл (-үүд)
<input type="checkbox"/> Хүү (хүү нар)	<input type="checkbox"/> Хойд эцэг	<input type="checkbox"/> Авга эгч(нар)	<input type="checkbox"/> Хадам(-ууд)
<input type="checkbox"/> Охин(охид)	<input type="checkbox"/> Ах(ах нар)	<input type="checkbox"/> Авга ах(нар)	<input type="checkbox"/> Бусад:
<input type="checkbox"/> Эх	<input type="checkbox"/> Эгч(эгч нар)	<input type="checkbox"/> Зээ(зээ нар)	
2. Таны гэр бүлийн гишүүдийн аль нэгэн урьд өмнөөс доор дурьдсан зүйлд өртөж байсан эсэх:
 Тийм Үгүй Эрүүл мэндийн асуудлууд
 Тийм Үгүй Сэтгэцийн эрүүл мэндийн асуудлууд ба/эсвэл эмчилгээ хийлгэсэн эсэх
 Тийм Үгүй Мансууруулах бодис согтууруулах ундаа хэрэглэж байсан ба/эсвэл эмчилгээ хийлгэсэн эсэх
 Тийм Үгүй Гэр бүлийн Хүчирхийлэл
 Тийм Үгүй Зөвлөгөө авах: хувийн ба/эсвэл гэр бүлийн (гэр бүл, бүлэг гэх мэт.)
 Тийм Үгүй Цэргийн байлдаанд оролцох
 Тийм Үгүй Зулбалт эсвэл үргүйдэл
 Тийм Бусад, тайлбарлана уу:
“Тийм” болгонд тайлбар өгнө үү, үүнд онош, огноо, эмчилгээний үр дүн ба/эсвэл хууль зүйн байгууллагын оролцоо зэрэг орно.

3. Та эсвэл таны гэр бүлийн аль нэгэн гишүүн Хүүхэд Хамгаалалтын Үйлчилгээд (CPS) оролцож байсан уу?

Тийм Үгүй

Хэрэв тийм бол тайлбарлана уу:

4. Таны гэрт эсвэл автомашинд тамхи татахыг зөвшөөрдөг үү? Тийм Үгүй

Ф. Гэр ба Хөршлөл

1. Та өөрийн гэрт/ хөршүүдтэй хир зэрэг удаан амьдарч байна вэ?

2. Та нийтийн ус хангамжтай эсвэл хувийн ус хангамжийн тогтолцоотой юу?

3. Таны гэр буюу таны эзэмшилд ямар нэгэн гарж болзошгүй аюул осол бий юу?

4. Та өөрийн эзэмшилд байдаг тэжээвэр амьтад эсвэл амьтдуудыг нэрлэнэ үү.

5. Энэ тэжээвэр амьтад эсвэл амьтад хүүхдэд хоргүй юу? Тийм Үгүй. Хэрэв үгүй бол та хүүхдийг уг амьтадтай хамтран аюулгүй нөхцөлд байлгах чухам ямаршуу төлөвлөгөө хийж байгаа вэ?

Г. Дэмжлэгийн Тогтолцоо

1. Та дэмжлэгт юу хэрэглэдэг вэ? Таны дэмжлэгийн тогтолцоо танд тус болсон цагийн тухай бичнэ үү.

2. Таны дэмжлэгийн тогтолцооны гишүүний аль нэг нь таны гэрт байрлуулсан хүүхэдтэй харьцах боломжтой юу? Хэрэв тийм бол, тайлбарлана уу.

Н. Гэр Бүлийн Санхүүжилт

1. Та нэмэлт хүүхдийг ямар нэгэн санхүүгийн нэмэлт туслалцаа авалгүйгээр асарч чадахдаа итгэлтэй байна уу? Хэрэв үгүй бол, танд ямар төрлийн санхүүгийн туслалцаа хэрэгтэй вэ?

2. Та ямар нэгэн өөр төрлийн санхүүгийн туслалцаа авдаг уу? Тийм Үгүй

Хэрэв тийм бол тайлбарлана уу:

I. Байнгын Боломж

ТЭМДЭГЛЭЛ: DLR нь бүх өргөдөл гаргачдад Нэгдсэн Гэр Бүл Судалгааг гүйцээж өгдөг. Гэр бүл судалгаа нь үрчилж авах ба байрлуултад гэр бүлийг зохицуулж баталдаг.

1. Та хүүхдийг өөрийнх нь төрсөн эцэг эх нартай эсвэл харгалзагч нартай аюулгүй байдлаар эргэн нэгтгэх үйлсэд ямар байдлаар дэмжлэг үзүүлэхээ тайлбарлана уу.
2. Та гэрээс гадуур асрагдаж байгаа хүүхдийн байнга тогтвортой байдлын талаар ямар ойлголттой байгаагаа тайлбарлана уу (гэртээ буцаж очих, үрчлэл, удаан хугацааны асаргаа).
3. Та санал зөвшөөрөөгүй тохиолдлуудад та хүүхдийг тогтворжуулах төлөвлөгөөг яаж, ямар байдлаар хүлээн авах вэ?
4. Үрчлэл/асаргаа/удаан хугацааны асаргааны тухай ойлголт нь “амьдралын турш явагдах бойжилт хөгжлийн явц ба амлалт юм” гэх үзлийг та өөрийн бодлоор тайлбарлана уу .
5. Төрсөн эцэг эхээсээ салсан хүүхдийн нүдээр харах орчинд өөрийгөө хүлээн авах байдал өөрчлөгдөж эргэлзлэлд орсон ба уг хүүхэд яаж энэхүү байдлыг сэтгэлээр эсвэл биеэ авч явах байдлаар илэрхийлж байхыг өөрийн бодлоор тайлбарлана уу. Та хүүхдэд түүний өөрийн бодлын төөрөгдөл ба алдагдалтай тэмцэхэд яаж туслахаа бичнэ үү.
6. Гэрээс гадуур асаргаанд байрлуулсан хүүхдэд ах дүү, төрөл садны нарын холбоо ямар их ач холбогдолтой байдгийг тайлбарлана уу.
7. Хэрэв хүүхэд таны гэрт байрласан ба тэр өөрийн төрсөн гэртээ эргэж очих боломжгүй тохиолдолд та байнгын түүнийг байлгах эх үүсвэр болж чадах уу? Яагаад ба яагаад бишийг тайлбарлана уу.

8. Та өөрийгөө хүүхдийн танайд байрлаагүй ах дүү нарыг байрлуулах түр байр олгох үүсвэр гэдэг талаас хардаг уу?
9. Та өөрийнхөө үрчилж авч болзошгүй гэх хүүхдэд нээлттэй харилцааны зөвшөөрөлийг авч үзэх үү, тэдний хамаатан садан ба/эсвэл төрсөн эцэг эх нартай хийгдэх удаан хугацаагаар асран хамгаалах зөвшөөрөлийг хүлээж авах уу? Тийм Үгүй
Яагаад тийм үгүйг тайлбарлана уу.
10. Та хүүхдэд үзүүлэх үрчлэл/асаргаа/удаан хугацааны асаргааг яаж, чухам ямархуу байдлаар төсөөлөн төлөвлөж байгаагаа тайлбарлана уу?
11. Та хүүхдийнхээ төрсөн эцэг эх нарын талаар, хамаатан садны талаар асуух асуултуудад юу гэж хариулж болохоо тайлбарлана уу.
12. Та хүүхдийн арьс өнгө, соёл, гарал үүслийн талаар үүсэх асуудал нь хүүхдэд болон таны гэр бүлд яаж ямар нөлөө үзүүлж болохыг тайлбарлана уу.
13. Таны гэрт байрлуулсан хүүхдийг асарч чадахгүй болсон тохиолдолд та өөрийнхөө төлөвлөгөөг тайлбарлана уу.

Ж. Хүүхдийн Онцгой Байдал

Та тодорхой хүүхэд таны гэрт байрлуулсан эсвэл байрлуулах болсон тохиолдолд үүнийг бөглөнө үү.

1. Та байрлуулалтыг нь хангахаар өргөдлөө өгсөн хүүхдийн талаар онцгойлон тайлбарлана уу.

2. Та хүүхдийн энэхүү өвөрмөц онцгой түүх болон түүний одоогийн хэрэгцээг ойлгож байгаа эсэхийг тайлбарлана уу.

3. Хэрэв хүүхэд танайд байрлавал та өөрийн талаас түүнд өгөх дэмжлэгүүдийн талаар тайлбарлана уу.

4. Та хүүхдийг өөрийн гэрээс гадуур байрлуулалтанд орж байгаа шалтгаануудыг сайн ойлгосон болохоо тайлбарлана уу.

К. Та бидэнтэй ямар нэгэн өөр мэдээллийг хуваалцмаар байна уу?

ГАРЫН ҮСЭГ	ОГНОО
------------	-------